



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх XVII.1.2.7 Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний хүрээнд батлагдсан Нэгдсэн эмнэлгийн дээвэр болон төрөх тасгийн их засвар /Архангай, Цэцэрлэг/ ажлын 212,790,617 /Хоёр зуун арван хоёр сая долоон зуун ерэн мянга зургаан зуун арван долоон/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Архангай аймгийн Засаг дарга /Ц.Мөнхнасан/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан, ажлын гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Архангай аймгийн Засаг дарга /Ц.Мөнхнасан/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080190